

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 25/08

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 болон 65 дугаар зүйлийн 65.3 болон 65.4 дэх заалтууд, 67 дугаар зүйлийн 67.1 болон 67.5 дахь заалтууд, 71 дүгээр зүйлийн 71.1 болон 71.3 дахь заалтууд, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Бодь Даатгал” ХК-ийн Дүрмийн 7.1 болон 7.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 сарын 13-ны өдрийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Бодь Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал /цаашид “Хурал” гэх/-ыг 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр 11:00 цагт “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн /Agm.bdsec.mn/ веб суурьтай аппликейшнийг ашиглан цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2025 оны 03 сарын 14-ний өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлсүгэй.
3. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компани, арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан 2025 оны 03 сарын 18-ны өдөр нийтэд мэдээлж, уг зарыг 2025 оны 04 сарын 02-ны өдөр дахин нийтэд мэдээлсүгэй.
4. Ногдол ашиг авах болон хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 сарын 04-ний өдрөөр тогтоосугай.
5. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2025 оны 03 сарын 21-ний өдөрт багтаан үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлсүгэй.
6. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
Хурал зохион байгуулах комиссын дарга: Гүйцэтгэх захирал А.Энхжаргал,
Гишүүд: Үйл ажиллагааны газрын захирал М.Мөнхбаатар, ТУЗ-н Нарийн бичгийн дарга Ө.Батчимэг, Үйл ажиллагаа хариуцсан ерөнхий менежер Ж.Наранцэцэг, Бүтээгдэхүүн Хөгжлийн менежер Г.Билгүүн, Ахлах хуульч Х.Сарангоо, Хуульч Б.Анар-эрдэнэ, Хөрөнгө оруулалтын алба С.Дөлгөөн
7. Хурлын зарын загвар, хэлэлцэх асуудлыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
8. Хурлын дэгийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

9. Хурлын танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар баталсугай.
10. Хурлын саналын хуудасны загварыг дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.
11. Хурлын материалыг 2025 оны 03 сарын 21-ний өдөр брокер, дилерийн компаниудад хүргүүлж, хувьцаа эзэмшигчдэд Хурлын материалтай ажлын өдрийн 10:00-17:00 цагийн хооронд ирж танилцах боломж бүрдүүлэхийг Гүйцэтгэх захирал болон Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
12. Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдэд саналаа урьдчилан өгөх боломжоор хангаж Компанийн өөрийн байранд, харилцдаг үнэт цаасны компаниар болон “БиДиСек” ҮЦК ХК-ийн Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, төв байр хаягаар дамжуулан урьдчилсан саналын хуудсыг хүлээн авах ба саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 15:00 цаг байна.
13. Хурлын даргаар Бодь Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал А.Энхжаргалыг томилсугай.
14. Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд: Тооллогын комиссын дарга: Ахлах хуульч А.Сарангоо, Гишүүд: Хуульч Б.Анар-эрдэнэ, Хөрөнгө оруулалтын алба С.Дөлгөөн нарыг ажиллуулахыг зөвшөөрсүгэй.
15. Хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Хурлын дарга, Хурал зохион байгуулах комиссын дарга А.Энхжаргалд даалгасугай.
16. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ө.Батчимэгт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН ГУДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.БИЛЭГТ